



Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдол

СЭДЭВ: “ЖЕНДЭРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГАХ НЬ” АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ
Чойбалсан хот, Дорнод аймаг
2018 оны 12-р сарын 7-8-ны өдөр

Техникийн зөвлөх Миша Гофорт

Яагаад “эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” хэрэгтэй гэж?

Жендэрийн тэгш байдал гэдэг нь бүх жендэрт тэгш эрх, боломж, бололцоо олгох тухай юм.

Тэгвэл *жендэрийн тэгш байдал* нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн АЛЬ АЛИНЫХ нь тухай юм бол бид яагаад “жендэрийн оролцоог нэмэгдүүлэх” аль эсвэл “хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх” тухай бус харин “эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” тухай ярьдаг билээ?


Хариулт нь маш энгийн:

ТЭГШ ЭРХ

Яагаад “эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” хэрэгтэй гэж?

Жендэрийн тэгш байдлыг
хангахын тулд эмэгтэйчүүд,
эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн өөр
өөр мэдлэг туршлага, хэрэгцээг
харгалзан үзэх ёстой.

Үүнийг *жендэрийн тэгш эрх* гэх
бөгөөд энэ нь хүн бүрт бодит үр
өгөөж хүртээхийн тулд нийгмийн
өөр өөр бүлэгт ялгаатай шийдэл
санал болгох хэрэгтэй гэсэн үг юм.



Яагаад “эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” хэрэгтэй гэж?

Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх тухай ярихад **тэгш эрх** маш чухал юм.

Монгол эрчүүд дундаж наслалт, дээд боловсрол эзэмших зэрэг зарим талаараа тэгш бус байгаа хэдий ч **ерөнхийдөө нийгмийн харилцаанд эрчүүд хангалттай эрх мэдэлтэй** байдаг.

Монголоор зогсохгүй дэлхийн бүх оронд эрчүүд жендэртэй нь холбоотой ‘**давуу эрх**’ (*privilege*) гэж нэрлэгдэх зүйлтэй байдаг.

Давуу эрх гэж юу вэ?

Давуу эрх бол:

- Та өөрөө хичээл зүтгэл гаргаж олоогүй ч танд угаасаа байдаг давуу тал эсвэл тусгай эрх
- Төрмөл зүйл
- Нийгэмд эзлэх байр суурийг нь дээшлүүлдэг аливаа **нэг бүлэгт** оноогдсон эрх мэдэл
- Нийгмийн нэг бүлэгт оноогдсон ч тухайн бүлэг дэх хүмүүс өгөөжийг нь хүртдэг
- Давуу эрх = эрх мэдэл

Давуу эрх гэж юу вэ?

Бид бүгдэд ямар нэгэн байдлаар давуу эрх **оршдог**, эсвэл давуу эрх **дутагддаг** талбар байдаг билээ.

Жишээлбэл: Дараах тохиолдлуудад давуу эрх хаана оршиж байгааг тодорхойлъё.

Улаанбаатар хотын бага орлоготой, өрх толгойлсон ээжтэй эсрэг хүйстэндээ татагддаг эмэгтэйн хувьд Япон улсын их, дээд сургуульд тэтгэлэгтэй суралцах боломжтой.

Тайлбар: Энэ тохиолдолд бага орлоготой, өрх толгойлсон ээжтэй, эмэгтэй гэсэн тодотголууд нь түүний хувьд давуу эрх дутагдаж байгаа талбар байж болно.

Улаанбаатар хотод хөрөнгөтэй, элэг бүтэн айлд төрсөн эсрэг хүйстэндээ татагддаг эрэгтэй. Гэвч тэр Хөгжлийн бэрхшээлтэй учраас тэргэнцэр хэрэглэх шаардлагатай болдог.

Тайлбар: Энэ тохиолдолд Хөгжлийн бэрхшээлтэй учраас тэргэнцэр хэрэглэх шаардлагатай гэсэн тодотгол нь түүний хувьд давуу эрх дутагдаж байгаа талбар байж болно.

Давуу эрх гэж юу вэ?

- Бидэнд давуу эрх байдаггүй бүхий л талбарт бид нэмэлт саад бэрхшээлийг давж гарах шаардлагатай болдог.
- Жендэрийн тохиолдолд эрэгтэйчүүд нийгэмд илүү их эрх мэдэлтэй бөгөөд эмэгтэйчүүдэд давуу эрх дутагдаж, нэмэлт саад бэрхшээлтэй тулгардаг.
- Давуу эрхтэй байна гэдэг нь амьдрахад хялбархан байна гэсэн үг огт биш. Энэ нь жендэрээсээ болоод нэмэлт саадыг даван гарах шаардлагагүй гэсэн үг.

Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдол

- Нийгэм дэх эмэгтэйчүүдэд тулгарч буй саад бэрхшээлийг даван гарахад нь тэдэнд туслахын тулд бид эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй.
- Эдгээр саад бэрхшээлүүд нь:
 - Ажлын байр, сургууль зэрэгт хүйсээр ялгаварлан гадуурхах үзэгдэл
 - Гэр бүлийнхний тэгэх ингэх ёстой гэсэн хүлээлт
 - Эмэгтэйчүүдийг доогуур албан тушаалд гацах, тодорхой зарим нэг ажлын талбарт ороход нь тушаа болдог хэвшмэл үзлүүд
 - Эмэгтэй хүн л үүрэх ёстой гэж тохоосон үүрэг, хариуцлага
 - Жендэрт суурилсан хүчирхийлэл
 - Мөн бусад олон зүйлс бий.

Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдол

Кейс №1: Ажлын байранд хүйсээр ялгаварлан гадуурхах

Үүрээ барилгын компанийн Мэдээллийн технологийн албанд ажилладаг. Түүний ажиллаж буй салбар болон ажлын байранд эрчүүд давамгайлдаг байсан тул ихэвчлэн өрөөндөө ганцаараа эмэгтэй нь байдаг байв.

Дарга, хамтран ажиллагсадтайгаа хийсэн нэг уулзалтын үеэр Үүрээ өөрийн саналаа бусаддаа хэлсэн. Түүнийг ярьж байх зуур бусад нь толгой дохиж байсан ч түүний саналуудын алиныг нь ч хүлээж авсангүй. Түүний дараахан тэр уулзалтад оролцсон өөр нэг эрэгтэй ажилтан Үүрээгийн хэлсэнтэй яг ижил санааг давтан хэлсэн. Энэ удаад түүний зөвлөмжийг нааштайгаар хүлээн авч, бүгдээрээ санал нийлж зөвшөөрсөн.

- Яагаад тухайн саналыг Үүрээ хэлэхэд тоохгүй байсан ч эрэгтэй ажилтан гарган тавихад хүлээн авсан бэ?
- Тэр эрэгтэй тухайн нөхцөлд өөрийн давуу эрхээ (эрх мэдлээ) хэрхэн ашиглахаар шийдсэн байна бэ?

Эрэгтэйчүүд чухал үүрэгтэй

- Бидэнд давуу эрх байгааг таниснаар бид үүнийг бусдыгаа дэмжих арга хэрэгсэл болгон ашиглаж болно!
- Эрэгтэйчүүдэд илүү эрх мэдэл байдаг учраас ажлын байранд, нийгэмд, гэр бүлд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд тэд маш чухал үүрэгтэй. Тодруулбал, тэд өөрсдийн илүү эрх мэдлийг эмэгтэйчүүдийг дэмжих БОЛОН тэгш бус байдлыг дэмжиж буй системийг өөрчлөхөд ашиглаж чадна.
- Жендэрийн тэгш байдлыг хангах ажилд эрэгтэйчүүдийг зориуд татан оролцуулсан үед байгууллагын 96%, тэднийг оролцуулаагүй үед байгууллагын зөвхөн 30% нь л ахиц олж хардаг болохыг судалгаагаар тогтоожээ.

Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдол

Кейс №2: Эрчүүд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хамтрагч болох нь

Үүрээ олон улсын байгууллагад ажиллаж байхдаа гадаад захирлынхаа дараа орох удирдах тушаалтан байв. Эрэгтэй хамтран зүтгэгсдээр хүрээлүүлсэн Үүрээ байгууллагын захирал, УИХ-ын гишүүний хоорондох уулзалтад оролцсон цор ганц эмэгтэй нь байлаа. УИХ-ын гишүүн уулзалтад хүрэлцэн ирэх мөчид тэрээр даргатайгаа зэрэгцэн зогсож, албан ёсоор өөрийгөө танилцуулахад бэлтгэж байв.

Үүрээ УИХ-ын гишүүн өрөөнд орж ирээд, захиралтай нь гар барин мэндлээд, дараа нь тэнд байсан бусад эрчүүдтэй гар барихын тулд түүнийг алгассанд гайхаж хоцров. Үүрээ гайхширч, бас хүчгүйгээ мэдэрч байв. Захирал нь Үүрээг алгасч, анхаарч үзэхгүй байгааг анзаарсан учраас УИХ-ын гишүүний өмнө түүнийг гаргаж, өөрийнхөө баруун гар хэмээн танилцуулсан.

- Гадаад захирал нь цагаан арьст эрэгтэй гэх давуу эрхээ хэрхэн ашигласан байна бэ?
- Захирлын сонголтын үр нөлөө нь юу байв?

Эрэгтэйчүүд чухал үүрэгтэй

- Эрэгтэйчүүд бодит байдалд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх үр нөлөөтэй хамтрагч байж чадна.
 - Өөрийн давуу эрхийг **таниарай!**
 - Эргэн тойрныхоо эмэгтэйчүүдийг **сонсоорой.**
 - Та хүйсээр ялгаварлан гадуурхсан эсвэл эмэгтэй хүнийг доош нь хийсэн санал сэтгэгдэл сонсвол **эмэгтэйчүүдийг өмгөөлөн дугараарай** (эргэн тойронд тань эмэгтэй хүн байхгүй ч байсан гэсэн!)
 - Өөрийн үзэл бодлоо **анзаарч**, хэлж буй үгээ сайн **цэнээрэй** (хэвшмэл үзлээс зайлсхийж, аль болох сөрөн зогсох)

Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдол

Эдийн засгийн, улс төрийн зэрэг нийгмийн чухал тогтолцоо нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг тэгш боломжоор хангаж чадахгүй байгаа тул “эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” нь жендэрийн тэгш байдлыг хангах болон Монгол Улсыг хөгжүүлэхэд нэн чухал.

Тийм учраас ажлын байр, бодлого, нийгэмд өөрчлөлт авчрахын тулд эмэгтэй, эрэгтэй хүмүүс хамтран ажиллах хэрэгтэй. Ингэснээр, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг тэгш боломжоор хангаж чадах юм.



Монгол Улс: Институцийн өөрчлөлт
хийх замаар эрдэс баялгийн
менежментийг сайжруулах нь

Хаяг: Нэйшнл таймс ньус тауэр, 3-р давхар
Худалдааны гудамж, Хороо 1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160

Утас: 7610-5000